



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

「 Барилга байгууламж балансаас баланст
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын 59 дүгээр сургуулийн баланст бүртгэлтэй, нийт 2,498,795,198.20 (хоёр тэрбум дөрвөн зуун ерэн найман сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун ерэн найман төгрөг хорин мөнгө) төгрөгийн үнэ бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг нийслэлийн ерөнхий боловсролын 156 дугаар сургуулийн баланст шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100487

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт



БАЛАНСААС БАЛАНСТ ШИЛЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (2022.12.31)	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Сургуулийн барилга	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хороолол	2016.09.01	м.кв	2660	2,231,445,108.70	362,766,609.88	1,868,678,498.82	Нийслэлийн ерөнхий боловсролын 156 дугаар сургууль
2	Уурын зуухны барилга		2016.09.01	ш	1	90,460,000.00	10,028,333.40	80,431,666.60	
3	Дэд станц /380v/		2016.09.01	ш	1	7,772,776.00	647,731.20	7,125,044.80	
4	Цэвэр усны шугам		2016.09.01	у/м	73,50	3,609,970.14	360,997.20	3,248,972.94	
5	Бохир усны шугам		2016.09.01	у/м	72,50	13,516,708.60	1,126,392.60	12,390,316	
6	Цахилгааны шугам		2016.09.01	у/м	480	13,685,236.80	1,140,436.20	12,544,800.60	
7	Гадна холбооны шугам		2016.09.01	у/м	800	29,454,648.00	2,454,553.80	27,000,094.20	
8	Гадна дулааны шугам		2016.09.01	у/м	292	76,587,176.20	6,382,264.80	70,204,911.40	
9	Гадна хашаа		2016.09.01	м.кв	276.76	32,263,573.76	16,131,786.60	16,131,787.16	
Нийт дүн						2,498,795,198.20	401,039,105.68	2,097,756,092.52	